



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Барилга байгууламж акталж, нийслэлийн
өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Сүхбаатар дүүргийн 75 дугаар цэцэрлэгийн хуучин барилгыг буулгаж, шинээр цэцэрлэг барих болсон, мөн Нийслэлийн “Хүрээ амаржих газар”-ын харуулын байрыг буулгаж шинээр хүчилтөрөгчийн үйлдвэр барих, тохижилтын ажил хийх болсонтой холбогдуулан нийт 289,043,787.39 (хоёр зуун наян есөн сая дөчин гурван мянга долоон зуун наян долоон төгрөг гучин есөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 191,124,290.30 (нэг зуун ерэн нэгэн сая нэг зуун хорин дөрвөн мянга хоёр зуун ерэн төгрөг гучин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад дурдсан барилга байгууламж болон нийтийн эзэмшлийн зам талбайн хөрөнгийг тус тус акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1115101:22

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн
116 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БОЛОН НИЙТИЙН
ЭЗЭМШЛИЙН ЗАМ ТАЛБАЙН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024.06.30/	Үлдэгдэл өртөг	Акталж данснаас хасах үндэслэл
1	Сүхбаатар дүүргийн 75 дугаар цэцэрлэгийн А байр	1954	м2	625	177,549,385.09	129,253,131.30	48,296,253.79	Нийслэлийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2013 оны 02-07-78/1975, 2022 оны 02-07-091/852 дугаар дүгнэлтээр буулгаж шинэ барилга баригдах болсон.
2	Дулааны шугам	1979	у/м	64	5,418,000.00	2,708,999.70	2,709,000.30	
3	Бохирын шугам	1979	у/м	57	4,680,000.00	4,290,000.00	390,000.00	
4	Цэвэр болон халуун усны шугам	1979	у/м	32	7,077,247.00	5,461,111.80	1,616,135.20	
5	Автомашины зогсоол	2012	м2	30	11,677,312.50	3,380,274.48	8,297,038.02	
6	Явган хүний зиг заг зам	2012	м2	614	11,019,442.50	3,189,838.74	7,829,603.76	
7	Гэрэлтүүлэг	2012	ш	12	4,131,000.00	2,840,062.50	1,290,937.50	
8	Тоглоомын талбай	2012	м2	850	32,967,675.00	22,665,276.48	10,302,398.52	
9	Мод, бут	2012	ш	36	183,600.00		183,600.00	
10	Зүлэгжүүлсэн талбай	2012	м2	950	16,773,580.00		16,773,580.00	
11	Навчит мод	1979	ш	16	230,950.00		230,950.00	
	75 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН АКТЛАХ ХӨРӨНГИЙН ДҮН				271,708,192.09	173,788,695.00	97,919,497.09	

1	Хүрээ амаржих газрын харуулын байр	1980	м2	31.5	143,395.30	143,395.30	-	Шинэ эмнэлгийн барилгад зориулсан контейнер хэлбэрт хүчилтөрөгчийн үйлдвэр (байгууламж) барих, гадна талбайн тохижилтын ажил хийгдэхээр болсон.
2	Гэрлийн шон	1959	ш	3	275,400.00	275,400.00	-	
3	Асфальтан талбай	2009	м2	1000	15,252,000.00	15,252,000.00	-	
4	Гадна хашаа	1959	м2	400	1,664,800.00	1,664,800.00	-	
	ХҮРЭЭ АМАРЖИХ ГАЗРЫН АКТЛАХ ХӨРӨНГИЙН ДҮН				17,335,595.30	17,335,595.30	-	
	НИЙТ ДҮН				289,043,787.39	191,124,290.30	97,919,497.09	

